

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ЛАБОРАТОРИ “ЭРДМИЙН ДАЛАЙ” ЦОГЦОЛБОР СУРГУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА



Тус сургуульд захирал, сургалтын менежер гэсэн 4 удирдах албан тушаалтан, 2 нийгмийн ажилтан, 72 багш, 37 ажилтан ажиллаж байна. Үүнээс бага ангийн 21 багш, дунд, ахлах ангийн нийт 51 багш, бага ангийн 807, дунд ангийн 591, ахлах ангийн 416 нийт 49 бүлгийн 1814 сурагч 2 ээлжээр хичээллэж байна.

Бага, дунд, ахлах, захиргаа аж ахуй гэсэн 4 хэсэгтэй. Нийт багш нарын 85% нь мэргэжлийн зэрэгтэйгээс Тэргүүлэх зэрэгтэй 26, Заах аргач зэрэгтэй 35 нийт 61 зэрэгтэй багш ажиллаж байна. Мөн боловсролын магистр зэрэгтэй 25 багш, мэргэшсэн нягтлан бодогч 1, аймгийн шилдэг багш давхардсан тоогоор 18, улсын шилдэг багш 2, улсын төрөлжсөн олимпиадын аварга багш 3-ыг төрүүлсэн.

Байгууллагын алсын хараа: Тогтвортой хөгжлөөр манлайлагч сургууль болох

Байгууллагын эрхэм зорилго: Өөртөө итгэлтэй бусдад зөв үлгэр дууриалал үзүүлдэг, бие даан хөгжиж мэндлэх, хүндлэх ёсыг эрхэмлэсэн суралцагчийг төлөвшүүлнэ.

Байгууллагын зорилтууд:

- Сурч ажиллах таатай орчинг бүрдүүлэх
- Сургалтын чанар, түвшинг ахиулах,
- Багшийн заах арга ур чадварыг дээшлүүлэх, залуу багшийн мэдлэг, ур чадвар, бүтээлч үйл ажиллагааг хөгжүүлэх
- Суралцагчдын авьяас чадварыг нээх, хөгжүүлэх, нийгмийн оролцоог нэмэгдүүлэх
- Лаборатори сургалтын үр өгөөжийг дээшлүүлэх
- Ёс зүйг эрхэмлэсэн, хамт олны бүтээлч идэвх санаачилгыг дэмжих
- Олон нийт эцэг, эхийн оролцоог өргөжүүлэх